


ХИМИЙН ХОРДЛОГЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН 7 ХОНОГИЙН МЭДЭЭ


НЭГ. Угаарын хийн цочмог хордлогын мэдээ

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хор судлал, шуурхай удирдлагын албанд 2025 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөс 2026 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар буюу **25-р долоо хоногт** нийт Нийслэлийн 8 дүүрэг, 11 аймагт **1269** хүн угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ аван.



Угаарын хийн хордлогод өртсөн иргэдийг байршлаар авч үзвэл:

Угаарын хийн хордлогод өртсөн 1269 тохиолдлын 94% /1189/ нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бол, 6% /71/ нь орон нутагт (Баян-Өлгий /10/, Баянхонгор /3/, Булган /1/, Говь-Алтай /11/, Дорнод /4/, Орхон /4/, Өвөрхангай /4/, Өмнөговь /3/, Төв /25/, Ховд /1/, Хөвсгөл /3/, Увс /1/), тодорхойгүй /2/ бүртгэгдсэн байна.




Нийслэлд угаарын хийн хордлогод өртсөн тохиолдлыг дүүрэг тус бүрээр авч үзвэл хамгийн өндөр буюу **357** тохиолдол Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн байна.


25 ДУГААР ДОЛОО ХОНОГТ

(2026.06.14 – 2026.06.20)


2026 оны хорин тавдугаар долоо хоногт 9 угаарын хийн хордлого бүртгэгдсэн байна. Өмнөх оны мөн үеэс 800 хувиар өссөн бол 5 жилийн дунджаас 40.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

**ХОЁР. Бусад химийн бодисын цочмог хордлогын мэдээ**

Цэргийн төв эмнэлгийн харьяа Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд **1-25 дугаар долоо хоногт нийт 833** иргэн химийн цочмог хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна.



2026 оны **хорин тавдугаар долоо хоногт** химийн цочмог хордлогод өртсөн **27** хүн хандаж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна. Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үеэс 8.00 хувиар, сүүлийн 5 жилийн дунджаас 121 хувиар тус, тус өссөн үзүүлэлттэй байна.



Хүснэгт 1. Химийн цочмог хордлого, шалтгаанаар (25-р долоо хоногт)

№	Шалтгаан (Сэдэл)	Санаатай	Санамсаргүй	Нийт
1	Химийн бодисын хордлого	4	8	12
2	Эмийн хордлого	13	2	15
Нийт		17	10	27

Нийт 27 хордлогын тохиолдол бүртгэгдсэнээс 15 (56%) нь эмийн хордлого, 12 (44%) нь химийн бодисын хордлого байна. Санамсаргүй хордлого 10 (37%) тохиолдол, санаатай хордлого 17 (63%) тохиолдол тус, тус бүртгэгдсэн байна. Энэ нь эм болон химийн бодисыг буруу хэрэглэх, хадгалах дадал сул байгааг илтгэн, урьдчилан сэргийлэх сургалт, мэдээллийг нэмэгдүүлэх шаардлагатайг харуулж байна.